

10 дүгээр сарын үйл ажиллагааны мэдээ**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар****Төрийн үйлчилгээний чиглэлээр:**

Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төвөөс төрийн албан хаагчдын дунд Төрийн албаны чанарын цахим судалгаанд төсөвт 5 байгууллагын нийт 90 төрийн албан хаагч хамрагдсан. Төрийн албаны тухай хуулийн 27-р зүйлийн 27,2 т заасны дагуу ЗДТГ төрийн захиргааны 1 сул орон тооны захиалгыг аймгийн төрийн албаны салбар зөвлөлд цаг хугацаанд нь хүргүүлж ажилласан.

Сумын төрийн бүх байгууллага, албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл гомдлын 3-р улирлын мэдээ нийт 74 өргөдөл гомдол ирснээс шийдвэрлэсэн 57 өргөдөл гомдол шийдвэрлэлт 77% -тай байна. Иргэдээс ирсэн өргөдөл гомдлын ихэнх хувийг гэр хүссэн өргөдөл ирсэн байна.

Улсын бүртгэл: Төрсний бүртгэл 12, насбарсны бүртгэл 2, гэрлэлтийн бүртгэл 1, иргэний үнэмлэх олголтын бүртгэл 30, иргэний үнэмлэх хүчингүй болсны бүртгэл 17 шилжилт хөдөлгөөний бүртгэл 16-аас дээш насны 23, 16-аас доош насны 28 нийт 51 иргэн шилжиж ирсэн. Эд хөрөнгийн улсын бүртгэл газар болон түүнтэй холбоотой 15 бүртгэл хийгдсэн. Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэл 7 хийгдсэн. Тоон гарын үсэг 101 иргэнд олгогдсон. Иргэний бүртгэлийн тоон мэдээ, үнэт цаасны тайлан, орлогын мэдээг 7 сарын 25 ны дотор хүргүүлсэн.

Хоёр: Нийгмийн бодлогын хүрээнд:**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР**

Албан газрын харьяалалгүй ахмадын жагсаалтыг хэлэлцэн 363 ахмадын хүндэтгэлийг ehalamj.mn системд бүртгэлээ.ХЭБҮ-ндэнэсардбөрхийн23 иргэний 296.0 мянган төгрөгийн санхүүжилт хийгдээд байна.

Ахмад настны протез шүдны хөнгөлөлт 4 иргэнд 520,0 мянган төгрөг, хөтөвч суултуур 5 иргэнд, бөөрний даруулга 5 иргэнд олгоод байна.

Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд 1 өрхийг хамруулж судалгааг ХХҮГазарт хүргүүлсэн.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хяналт шалгалт хийгдэж Асруулагч нь нас барсан 2 асаргааны илүү олгосон тэтгэмж 169,0 мянган төгрөг, илүү олгосон 2 тэтгэвэр 364850 төгрөгийг 100900017033 дансанд татан төвлөрүүлсэн.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР

Хөдөлмөр эрхэлтийг дэмжих сангаас олгогдох Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих төсөл 9 сарын 29-ны хүртэл зарлагдаад байна.

Баян-уул багийн иргэдийн нийтийн хуралд цаг үеийн болон ХЭДСангийн төсөл хөтөлбөрийн талаар мэдээлэл өгсөн.

Нийгмийн даатгал:

Сайн дурын даатгалд төлөвлөгөөгөөр 9 сарын байдлаар СДД-д 480 хамрагдахаас 251 хамрагдсан орлогын төлөвлөгөө 104409,6 төвлөрөхөөс 82225,5 төвлөрч 78,8 хувьтай байна. Эхчүүдийн сайн дурын даатгалын орлого 94 эх хамрагдахаас 81 эх хамрагдсан. Шимтгэлийн орлого ажил олгогчоос орох төлөвлөгөө 317503,1 гүйцэтгэл 287958,4 , хувь 90,7 байна.

Ерөнхий боловсролын сургууль:

2023-2024 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагааг амжилттай эхлүүлж, нээлтийн үйл ажиллагаа “Сургуулийн 100-н жилийн ой “-г угтаж явагдсанаараа онцлог байлаа. Энэ хичээлийн жилд тус сургуулийн 51 багш, 33 ажилтан, 5 удирдлага 1021 сурагчдад боловсролын үйлчилгээ үзүүлж байна. Насан туршийн боловсролын 7 суралцагч байна. Хэлмэгдэгсэдийн өдрөөр ахлах ангийн сурагчдын дунд “Хэлмэгдүүлэлт миний нүдээр” ЭССЭ бичлэгийн уралдаан болж 11а ангийн сурагч И.Энхмөрөн түрүүлж бахдам амжилт үзүүллээ. 9 сарын 13 өдрөөс эхлэн ЕБС-ийн нэгдүгээр ангийн суралцагчдын сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх үнэлгээ 3 дахь жилдээ амжилттайгаар явагдаж өнгөрлөө. 9 сарын 14 нд Ёс зүйн багаас шинээр ажилд орсон багш нарын Тангараг өргөх ёслолын арга хэмжээг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд 5 багш оролцож тангараг өргөлөө. Хувь хүний ур чадвар, энтрепренер боловсрол олгох хөтөлбөрийн хүрээнд ЕБС-ийн сурагчдын хоёр анги нээгдлээ. Энэ жилийн хоёр ангийг хөгжмийн багш Л.Энхээ, дотуур байрын багш Н.Рэгжидмаа нар удирдан чиглүүлнэ. Тус сургалтанд 8,9-р ангийн нийт 48 хүүхэд хамрагдаж байна. Залуу багш нартаа арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор НУЗАН-ээс санаачлан УРИЛГАТ хичээлүүдийг зохион байгуулан ажиллалаа. Мөнххаан ЕБС-ийн 100-н жилийн ойн ажлын хүрээнд “Уламжлалт намрын спартакиад” 5 төрлөөр зохион байгуулагдаж ахлах, дунд, бага насны ангилалд үеийн бүлгээрээ оролцож аваргуудаа шалгарууллаа. 2023-2024 оны хичээлийн жилд эцэг эх эргүүлийн үйл ажиллагаа идэвхитэй явагдаж сурагчдыг зам тээврийн болзошгүй эрсдэл болон сургуулийн орчинд гарч болох осол гэмтлээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна.

Сургуулийн гадна, дотор орчныг 9 сардаа багтаан бүрэн камержууллаа. “Талын Гал” ХК-ийн Талбулагийн нүүрсний уурхайтай хамтран гэрээ байгуулж өвөлжилтийн бэлтгэл хангалаа. 25 тонн нүүрсний нөөцтэй байна.

Хүүхдийн цэцэрлэг:

2023-2024 оны хичээлийн жилд хамран сургалтын хувийг нэмэгдүүлэн ердийн бүлэгт 270, хувилбарт сургалтаар 120 хүүхэд , нийт 390 хүүхэд суралцаж байна.

2023-2024 оны хичээлийн жил эхэлж байгаатай холбогдуулан бүх багш ажилчид аймгийн ЭМГ-т урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдлаа.

Цэцэрлэгтээ дасан зохицох, хүүхдийн хөгжлийн арга зүйн талаар 10 бүлгийн дотоод группээр дамжуулан эцэг эхэд зөвлөгөө зөвлөмж хүргэж ажиллав.

Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хууль шинэчлэгдэж, эдгээрийг танилцуулах хуулийн өдөрлөгийг зохион байгууллаа. Мөн хууль эдгээр шинэчлэгдэн батлагдаад, хэрэгжиж эхэлж байгаа хуулиудыг постер хэлбэрээр цувралаар боловсруулан эцэг эх, олон нийтэд танилцуулах ажлыг байгууллагын цахим хаягаар дамжуулан хүргэлээ.

Өвөлжилтийн бэлтгэл хангаж, хичээлийн 1-р байрны хагарсан цонх шиллэх, хагарсан халаалтын секц солих ажлуудыг хийж дуусгав.

Цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан, 09 сарын 21-ний өдрөөс эхлэн байгууллагын халаалтын ажлыг эхлүүлээ.

Байгууллага дээрээ “Судар эгшиглэн -2023” төслийн оролцоог өмнөх жилийнхээс өөр, шинэлэг арга зүйгээр хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлэн, багш ажилтан бүр сард уншвал зохих номоо уншиж тэмдэглэл хөтөлж байна. “Эко сургууль цэцэрлэг” хөтөлбөрт хамрагдаж, “Хүрэл гэрэгэ” авах болзлыг ханган 9 чиглэлээр, 19 шалгаруулалтын дагуу материалаа боловсруулан илгээлээ.

Баруун-Уртын Мандарваа цэцэрлэгтэй хувилбарт сургалтыг зохион явуулж буй туршлагаа түгээн дэлгэрүүлэх, харилцан судлах нээлттэй арга хэмжээг өөрийн цэцэрлэг дээрээ зохион явуулж, 2 цэцэрлэгийн нийт 16 багш оролцлоо.

Эрүүл мэндийн чиглэлээр

2023 оны 9 сард нийт 35 хүн хэвтэн эмчлүүлсэн. Үүний 32 насанд хүрэгчид, 3хүүхэд байна. 9 сарын 20-21-ны АНЭ-ийн нарийн мэргэжлийн эмч нарын явуулын амбулаторийн үзлэг хийгдсэн. Глобаль сангийн дэмжлэгтэй Монгол улсад ДОХ, Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнийг эмчлэх үндэсний тогтолцоог бэхжүүлэх, дэмжлэг үзүүлэх төслийн хүрээнд 2023 оны 09 сарын 20-21-ний өдрийг хүртэл 2 хоногийн хугацаанд Эрүүл мэндийн цогц үзлэгийг манай суманд эрсдэлт бүлгийн иргэнийг хамруулахаар зохион байгуулж ажилласан.

1. Мөнххаан сум хамрагдвал зохих хамрагдсан 140/98/ 70%
2. Үүнээс сүрьеэгийг эмчилгээнд хамрагдсан -8, ойрын хавьтад -90
3. 5-17 насны 70 хүүхдэд сорил тавьсан. Нийт сорил тавьсан хүүхдүүдийн сорилыг 72 цагийн дараа шалгахад
 - Хэвийн – 68
 - Хэвийн бус бэрсүү үүссэн – 2 шалгагдлаа.

Нийт лаборатори шинжилгээ -456

- Үүнээс тэмбүү-37 / баталгаажуулна
- ЭМД-гүй 58 хелик-44 сахар-5 холестерин-2 тэмбүү-3

Түргэн тусламжийн дуудлага 21 ирснээс алсын дуудлага 4, ойрын дуудлага 17 ирсэн. Цаг тухай бүрд нь барагдуулсан. Яаралтай тусламжаар 27 хүн үйлчлүүлснийг шивж баталгаажууллаа.

ГУРАВ: ТӨСӨВ САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Санхүү алба нь хуваарийн дагуу 9 сарын 1-6 ны хооронд төсөвт байгууллагын 8-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг гарган хянан баталгаажуулж ажиллалаа. Мөн дээрх хугацаанд төсвийн орлого, зарлага, бүтэц орон тоо, төсвийн хуваарийн дагуу олгогдсон санхүүжилт 5 саяаас дээш гүйлгээ , өр авлагыг [www. shilendans.mn](http://www.shilendans.mn) сайт руу шивж ил тод байдлыг мэдээллэсэн. Төсвийн тодотголын хуваарийг аймгийн төрийн сангийн хэлтэст тушааж бааз татуулсан. Сумын ОНХС-ын гүйцэтгэлд үнэлгээний баг ирж ажиллаж 2 хоног ажиллаж үнэлгээ хийсэн. 2022-2023 оны худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичгийг санхүү аудитын газарт хүргүүлж ажилласан.

Дөрөв : Мал эмнэлэгийн болон ХХАА-н чиглэлээр:

МЭТ 9 сард Хонины мах 80116 кг, Адууны мах 49106 кг, Үхэрийн мах 57602 кг, Ямааны мах 16731 кг нийт 203555 кг махыг хянан баталгаажуулж ажилласан.

Хонь хурганд цэцэгийн вакцинжуулалт хийгдсэн нийт 113.203 мянган хурга хамрагдсан

Тав : Байгаль орчин газар зохион байгуулалтын чиглэлээр:

Нэг: Газрын хэвлий, ТХГН, уул уурхайн талаар /холбогдох зураг/

Тус сумын Баянтэрэм 1-р багийн нутаг Өлзийт хэмээх газар хууль бусаар ашигт малтмал олборлолтын ажил хийж, жонш ялгаж байгааг таслан зогсоож аймгийн Цагдаагийн газарт шилжүүлсэн. Ашиглаж байсан 2 техникийг лацадсан. Хяналт шалгалтыг Багийн даргатай хамтран 3 удаа хийсэн. Үүнд 30л шатах тослох материалыг зарцуулсан. Мөн Хунт-Өгөөж ХХК-ны усны тоолуурыг сар бүрийн 25-нд бичилтийг хийхэд 1-р амны тоолуур эвдэрсэнг солиулж шинэ тоолуурыг мэргэжлийн байгууллагаар тавиулсан.

Хоёр: Ногоон байгууламжийн талаар /Холбогдох зураг/

Тус сумын 2022 оны тарьсан мод, 2023 оны тарьсан модонд хяналт мониторинг хийж ажлын хэсгийн хамт тооллого хийсэн. Уг тооллогоор модны ургалтын хувь 93.3%-тай байна. Тооллогоны дүн мэдээг холбогдох мэргэжилтэнд хугацаанд нь хүргүүлсэн. 2022 онд үрээр хүлэмжинд тарьсан мод 100 хувь ургасан. Энэ намар худалдаанд гаргана.

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ТГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

О.ТУЯА.